*Г.Лхагвамаа- ДХИС-ийн ДХИС-ийн Удирдлагын академийн*
*Аюулгүй байдлын удирдлага, стратеги*
*профессорын багийн профессор,*
*доктор, дэд хурандаа*
*З.Эрдэнэ-Оргил- ДХИС-ийн Удирдлагын академийн*
*8111 дүгээр дамжааны магистрант, Цагдаагийн хошууч*

# ТЕРРОРИСТ ҮЙЛДЛИЙН СӨРӨГ ТУСГАЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙУУЛАЛТЫН АСУУДАЛД

***Товч агуулга:*** *Энэхүү илтгэлийн зорилго нь терроризм, террорист үйлдэл, түүнтэй тэмцэх сөрөг тусгай ажиллагааны онол арга зүйн үндэс, сөрөг тусгай ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.*

***Abstract:*** The purpose of this article is to analyze current situation of counter operational management in Mongolia focusing on theoretical and methodological issues of terrorism, terrorist actions as well as special counterinsurgency activities and to identify ways to solve the problem.

***Түлхүүр үгс:*** Терроризм, террорист үйлдэл, сөрөг тусгай ажиллагаа, сөрөг тусгай ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, өнөөгийн байдал

***Key words:*** Terrorism, terrorist act, special counter operation, counter intelligence management, current condition.

## Оршил

“Энхийн цагт, урдын болон өнөөгийн хийж бүтээснээ гайхуулахын оронд, харгис хэрцгий террорист халдлагаас сэргийлэх, хамгаалах замаар аюулгүй байдлаа хангах нь улс орноо тогтвортой хөгжүүлэх, хүн ардаа амгалан тайван амьдруулах, амьдралынх нь төвшинг дээшлүүлэхэд тус дэмтэй” хэмээн доктор Ш.Паламдорж илтгэлдээ тэмдэглэсэн нь террорист үйлдлийн аюул заналыг илрүүлж, урьдчилан сэргийлж таслан зогсоохын ач холбогдлыг энгийн иргэдэд ойлгомжтой тодорхойлжээ.

Үүнээс үзэхэд терроризм, түүнтэй тэмцэх ажиллагаа нь хэзээ ч үл орхигдож болох нэг чухал асуудал бөгөөд Монгол улсын хувьд энэхүү ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд түүнийг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхойлон заасан хэдий ч тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны нэгдсэн удирдлагын механизм байхгүй байгаа нь энэхүү сэдвийг судлах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Улс орон бүр өөр өөрсдийн үзэл санааг шигтгэсэн терроризмтэй тэмцэх стратегийн төлөвлөгөө

боловсруулж хэрэгжүүлдэг бол манай улсад энэ асуудал нь хараахан боловсронгуй болоогүй байгаа нь судлаачдын анхааралыг ихэд татаж байна.

Цаашид олон улсын туршлага, харьцуулсан судалгааны үндсэн дээр өөрийн улс орны эрх ашигт нийцүүлэн террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлэх асуудлыг хөндөн практикт хэрэгжүүлэх боломжтой саналыг дэвшүүлэн тавьж байгаад энэхүү судалгааны ач холбогдол оршиж байна.

## Нэг. Терорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа, олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт

*Терроризмын ойлголт*

Терроризм гэдэг ойлголтыг танин мэдэхийн тулд “террор”, “терроризм” гэсэн хоёр нэр томъёог хэрхэн ойлгох вэ? “Террор” гэсэн нэр томъёо нь “terror” буюу аймшиг, айдас гэсэн латин үгнээс гаралтай ажээ.

Польшийн эрдэмтэн А.Бернгардын илэрхийлснээр “террор” бол төр засгийн эрх баригчидад хамаарах ойлголт бөгөөд цэрэг, цагдаа зэрэг хүчний байгууллагаараа дамжуулан залхаан цээрлүүлэх, хэлмэгдүүлэх, дарангуйлах гэх мэт хүчтэй нь хүчгүй, хамгаалалтгүйдээ үзүүлэх үйл ажиллагаа аж. Харин “терроризм” бол сөрөг хүчин болж буй талд хамаарах ойлголт бөгөөд өөрсдийн хүсэл, зорилгоо биелүүлэх хүчин мөхөсдөж буйн улмаас айлган сүрдүүлэх, занданчлах үйлдэл[1] гэж үзсэн байдаг.

А.Бернгардын илэрхийлснээр авч үзвэл Европ болон Евро-Азид 1933-1945 онд германчуудын хөнөөсөн 6 сая еврейчүүд бол терроризм бус, харин нацист Германы төрөөс явуулсан террорын үр дагавар, тэр нь геноцид болон хувирсан байж таарч байна.

Гэтэл зарим эрдэмтэн судлаачид террорыг терроризм гэж үздэг. Жишээ нь “Аливаа үйл ажиллагааг бодлогогүй, зорилгогүй үйлдэх үү? Нэлээд тохиолдолд улс төрийн тодорхой зорилготой байна. Тиймээс террор нь терроризм гэсэн ойлголтод багтах бөгөөд түүнээс салангид томъёолол, ойлголт, үйлдэл биш” гэж Шинжлэх ухааны доктор, профессор Ш.Паламдорж нарын монгол эрдэмтэд үзсэн байна.

Доктор Ч.Баатар /Терроризмын эсрэг Монголын холбооны тэргүүн, Аюулгүй байдал, хамгаалалтын академийн ерөнхийлэгч, Олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тамцэх дэлхийн форумын Монгол Улсад суугаа байнгын төлөөлөгч/-ын бичсэнээр “Терроризм гэдэг нь үзэл сурталжсан хүчирхийлэл дээр үндэслэгдсэн бөгөөд системтэйгээр хэрэглэгддэг улс төрийн тэмцлийн арга хэлбэр юм, Терроризм нь улсын болон төрийн бус байгууллага, иргэд, бусад субъектуудэд өөрсдийн ашиг сонирхлын үүднээс тодорхой халдлага үйлдэх замаар зорилгодоо хүрэх явдлыг хангаж байдаг, нийгмийг айдаст автуулах хүчирхийллийн систем юм ”*[2] гэжээ.

[1] *Паламдож Ш. Терроризм, түүнээс сэргийлэх. УБ. 2003. 8 дахь тал*
[2] *Баатар Ч. Терроризм, аюулгүй байдал . УБ. 2006 7 дахь тал*

Монгол улсад 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Их хурлаар батлагдсан Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хуулиар “терроризм” гэж “Улс төр шашин, үзэл суртал эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшигийн нөхцлийг бүрдүүлэх үйл ажиллагааг”[1] хэмээн тодорхойлжээ.

Дэлхийн хамтын нийгэмлэг өнөөдрийг хүртэл терроризм, түүний шинж чанар, онцлогийн талаар нэгдсэн тодорхойлолтыг гаргаж чадаагүй байна. Терроризмын тухай олон улс орон, тэдгээрийн эрдэмтдийн дүгнэснээр 100 гаруй ойлголт байгаа боловч тэдгээрийн нэг нь ч сонгодог ойлголт болж нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй хэвээр байна гэж үздэг юм байна.

Терроризмын тухай ойлголт ийнхүү зөрөөтэй байгаа нь түүний зорилго, шинж чанар, онцлог, арга хэлбэр, шалтгааныг өөр өөрөөр тодорхойлж, тайлбарлаж байгаатай холбоотой юм.

Терроризм нь зорилгодоо хүрэх онцгой харгис үйлдлийг зөвтгөсөн, хөрөнгө, санхүүгээр дулдуйдсан, зэвсэг, хөнөөх хэрэгслийн хүчинд тулгуурласан экстремитс, салан тусгаарлагч үзэлтэй харгис цөөн хүний хүрээллийн дотор маш нууц бэлтгэгдэж, шуурхай ажиллагаа явуулдаг, үндэстэн дамжсан эрүүгийн онц ноцтой гэмт хэргийн шинжтэй хүчирхийлэл болсоор байна.

Дээрхээс дүгнэхэд “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд онцгой харгис үйлдлийг зөвтгөн, нийгэмд бүхэлд нь, эсвэл түүний тодорхой хэсэгт айдас, аймшиг төрүүлэх зорилгоор энгийн иргэд, эд хөрөнгийн эсрэг зориуд санаатайгаар үйлдэж буй хэт харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх үйлдлийг хэлнэ” гэж тодорхойлж болохоор байна.

*Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны ойлголт*

Террорист үйлдлийг таслан зогсоох, террорист этгээдийг аюулгүй болгох, баривчлах, хүн, хуулийн этгээдийн аюулгүй байдлыг хангах, хор уршгийг бууруулах зорилгоор цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон төрийн цэргийн байгууллагын томилгоот хүч хэрэгслээр нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгдсэн удирдлагаар гүйцэтгэх цогц ажиллагааг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа гэнэ.[2].

Терроризмтой хийх тэмцэл нь дэлхий ертөнцийн түүхэнд гарч байсан аль ч дайнаас зорилго, далайц, оролцож буй бүрэлдэхүүн, хэрэглэх тактик, зэвсэг, арга хэрэгслэлээрээ эрс ялгаатай. Терроризмтой хийх тэмцэлд гагцхүү

[1] *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1 дүгээр хэсгийн 3.1.1 дэх заалт*

[2] *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1 дүгээр хэсгийн 3.1.10 дахь заалт*

цэргийн хүчээр ялалт байгуулах боломжгүй юм. Ялагч болохын тулд төрийн байгууллын бүх субъектуудыг ашиглан улс төр, дипломат, эдийн засаг, хууль эрх зүй, санхүү, мэдээлэл, тагнуул, цэргийн арга хэрэгслийг нэн зохистой хослуулан, дээд зэргийн үр бүтээлтэй хэрэглэх нь онцгой чухал болсоор байна.

Террорист үйлдэлд терроризмын зорилгоор галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, химикатын, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг хэрэглэж иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учруулах, буюу аюул учруулахаар заналхийлэх, төр, нийгмийн зүтгэлтэн, угсаатны болон шашны байгууллагын төлөөлөгчийн амь насанд халдах, хүн хулгайлах, хүн, объект барьцаалах, техникийн холбогдолтой гамшиг ослын нөхцөл бүрдүүлэхийг хамааруулжээ.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын болон цэргийн хамтарсан хүч хэрэгслээр тусгайлан хэрэгжүүлэх дараахь ажиллагаа хамаарна:

- Террорист үйлдлийг илрүүлэх, хүн, хуулийн этгээдийг хамгаалах
- Террорист үйлдэлд өртсөн хүн, эд хөрөнгийг аврах;
- Террорист үйлдлийн шалтгаан нөхцөлийг арилгах;
- Террорист үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах;
- Террорист этгээдийг баривчлах, аюулгүй болгох;
- Террорист үйлдэлд ашиглаж байгаа болон ашиглахад зориулсан эд хөрөнгө, эд зүйл, юмс, мөнгөн хөрөнгө, террорист үйл ажиллагаа, үйлдлээс олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, хураах;
- Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр бэлтгэж явуулах хууль тогтоомжид заасан бусад тусгай ажиллагаа.

Террорист үйлдэлтэй тэмцэхэд хэрэглэх үндсэн зарчим, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хор уршгийг арилгах арга хэмжээг тодорхойлох шаардлагатай.

Терроризмтой тэмцэх зарчим гэдэг нь төрийн бүх шатны байгууллагаас терроризмаас сэргийлэх, террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаа явуулахдаа анхааран үзэж, мөрдлөг болгох удирдамж, зөвлөмж болохуйц үзэл баримтлалын илэрхийлэл юм. Терроризмтой тэмцэх үндэсний стратеги нь терроризмтой тэмцэх үндсэн зарчмуудад тулгуурлана. ***Терроризмтой тэмцэх үйл ажиллагааны зарчим***[1] нь:

- Тогтвортой, цогц, уялдаа холбоотой, шуурхай, тасралтгүй байх,
- Терроризмын аюулд өртсөн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болох хохирол, хор уршгийг багасгах,
- Терроризмтэй тэмцэх арга, техник хэрэгсэл,оролцогчдын нууцлал, аюулгүй байдлыг хангах,

[1] *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хуулпйн 4 дүгээр зүйл*

- Терроризмтэй тэмцэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага нэгдмэл, төвлөрсөн, тогтвортой байх,
- Судалгаа шинжилгээнд суурилсан, шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, шинэ мэдлэгт үндэслэсэн байх,
- Төрөөс хүн, хуулийн этгээд, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх байна.

Террорист үйлдлийн *сөрөг тусгай ажиллагаа явуулах журмыг* Монгол Улсын Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хуулиар дараах байдлаар тодорхойлсон байна.Үүнд:

- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг Монгол улсын олон улсын гэрээ, энэ хууль болон холбогдох бусад хууль,түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журам зааврын дагуу явуулна.
- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах журам, зааврыг Зөвлөлийн дарга батална.
- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн хүнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу урамшуулал олгоно.
- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрэм, журам зааврын нууцын зэрэглэлийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэн тогтооно[1] .

Террорист үйлдлийн сөрөг ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахдаа хэлбэрдэх, туйлшрахаас ангид байж, үүсэн бий болсон нөхцөл, байдал, түүний цаашдын өрнөлийг зөв төсөөлж, оновчтой шийдвэрийг зоригтой гарган, түүнийгээ тууштай хэрэгжүүлэх нь тухайн ажиллагаанд тохоон томилогдон оролцож буй хэн бүхний төр, иргэдийнхээ өмнө хүлээсэн нэн хариуцлагатай үүрэг болно.

*Эрх зүйн зохицуулалт*

Олон улсын терроризмыг аюулт дайснаа гэж үздэг улс орон бүр терроризмын үйл ажиллагаатай тэмцэх талаар олон улсын конвенциудад нэгдэн орж мөрдөх, түүний зүйл заалтад улсынхаа хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээг авсаар байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38-р зүйлийн 2 дахь хэсгийн 7-д Засгийн газар нь “хүний эрх эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх”[2] тухай заасан

[1] *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйл*

[2] *Монгол улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт*

бөгөөд дээрх үүргийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар төрийн хуулийг биелүүлж олон улсын өмнө хүлээсэн терроризмтэй тэмцэх үүргээ биелүүлэхдээ тусгай бэлтгэлтэй тактикийн бүлгийн хүч хэрэгслийг ашиглан сөрөг тусгай ажиллагаа явуулан тэмцэх бөгөөд уг ажиллагаа нь Монгол улсын Үндсэн хууль, терроризмтэй тэмцэх чиглэлээр Монгол улсын нэгдэн орсон гэрээ конвенц, Үйл олноор хөнөөх зэвсэгдэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Гадаадын цэргийн хүчийг байршуулах дамжин өнгөрүүлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Хилийн тухай хууль болон бусад хуулиуд, Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрэм, тэдгээрт нийцүүлэх гаргасан эрх зүйн бусад актуудаар зохицуулагдана.

*Хүснэгт 1 .Монгол улсаас нэгдэн орсон эрх зүйн акт*

| № | Нэгдэн орсон эрх зүйн акт | Хүчин төгөлдөр болсон огноо | Нэгдэн орсон огноо |
|---|---|---|---|
| 1 | Хүн барьцаалахын эсрэг конвенц. | 1983 он | 1992 он |
| 2 | Алан хядах зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай конвенц. | 2001 он | 2000.08.31 |
| 3 | Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенц. | 2002 он | 2003 он |
| 4 | Олон улсын хамгаалалтад орох хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц. | 1977 он | 1974 он |
| 5 | Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдэлтэй тэмцэх тухай конвенц | . 1971 он | 1971 он |
| 6 | Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц. | 1973 он | 1972 он |
| 7 | Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудал дахь хүчирхийлэл хэрэглэсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай нэмэлт протокол | 1989 он | 1999 он |
| 8 | Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэг тавих тухай конвенц | 1998 он | 1999 он |
| 9 | Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц. онд хүчин төгөлдөр болсон | 1987 он | 1986 он |
| 10 | Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц | 1969 он | 1990 он |
| 11 | Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц | . 1992 он | 2005 он |
| 12 | Эх газрын хормойд байрлуулсан, суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол | 1992 он | 2005 он |
| 13 | Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай конвенц. | 2005.09.14 | 2006.12.31 |

## *Хоёр: Сөрөг тусгай ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал*

*Сөрөг тусгай ажиллагааны удирдлагын өнөөгийн байдал*

Дэлхий даяар терроризмтэй тэмцэх талаар үндэсний стратегийг боловсруулан бусад улс оронтой холбоо тогтоон террорист үйлдлийг таслан зогсоох ажиллагааг зохион байгуулж байна. Жишээ нь:[1]

*Хүснэгт 2. Гадаадын зарим улсын терроризмтэй тэмцэх үндэсний стратеги, бодлого*

| д/д | Улс | Терроризмтэй тэмцэх үндэсний стратеги, бодлого |
|---|---|---|
| 1. | АНУ | Эх орныхоо үндэсний эрх ашиг, ард иргэд, анд нөхөд, холбоотнуудаа олон улсын террорист халдлагаас сэргийлэн хамгаалах, террористууд, тэднийг дэмжин тэтгэгч, өөгшүүлэн турхирагч хэн бүхнийг эсэргүүцэн тэмцэх уур амьсгал, үйл хэргийг дэлхийн өнцөг булан бүрт бүрдүүлэх явдал мөн |
| 2. | ОХУ | Терроризмтой тэмцэх гэдэг нь террорист ажиллагааг сэрэмжлүүлэх, илрүүлэх, таслан зогсоох, үр дагаварыг аль болохоор багасгах ажиллагаа” мөн |
| 3. | Израйль | Террористуудад буулт хийж болохгүй, тэднийг хаана ч болов, ямарч аргаар хамаагүй устгах хэрэгтэй |
| 4. | БНХАУ | Терроризмын эсрэг олон улсын тэмцэлтэй алхаа нийлүүлэн, хамын ажиллагааг сайжруулахын зэрэгцээ дотоодын салан тусгаарлагч болон террорист бүлгүүдтэй хийх тэмцэлээ эрчимжүүлж, хяналтаа сайжруулах, |
| 5. | Их Британи | Мэдээлэл, тагнуулын мэдээг цуглуулж, нэгтгэн дүгнэлт гаргах арга хэмжээ.<br>Урьдчилан сэрэмжлүүлэх, хамгаалах арга хэмжээ.<br>Терроризмын сүлжээг устгах, терроризм үүсэх шалтгаан нөхцлийг арилгах зорилгоор өөрийн орныхоо нутаг дэвсгэрт болон хилийн чанадад шийдвэртэй хэрэгжүүлэх өргөн цар хүрээтэй арга хэмжээ<br>Хямралын үеийн ажиллагаа хийгээд террорист үйлдлийн үр дагварыг арилгах арга хэмжээг багтаасан байна. |

***Монгол Улс*** нь терроризм шууд нүүрэлчихээгүй, харьцангуй тайван, тогтвортой дэлхийн цөөн хэдэн улсын нэг билээ. Энэ онцлог байдлаа цаашид хадгалан дархлаажуулах явдал манай улсын терроризмтой тэмцэх бодлогын үндэс байх учиртай.

Терроризмтой тэмцэх, түүний дотор террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах нь хүний эрх, эрх чөлөөг ямар нэг хэмжээгээр хязгаарлахад хүргэх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул занал, хохирол учруулж болохуйц үйлдэл хийлгэхийг шаарддаг тул терроризмаас сэргийлэх, террорист

*[1] Дашзэвэг Ц., Чагнаадорж Д. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарйм асуудалд. УБ. 2004 он 44 дэх тал.*

үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг гагцхүү хуулийн хүрээнд, зөвхөн хуулийн дагуу явуулах ёстой.

Монгол улсын терроризмтэй тэмцэх сөрөг тусгай ажиллагааны удирдлагын хувьд нийт нутаг дэвсгэрээ террорист болон олон улсын терроризм нэвтрэх, орогнох, нутагших боломж олгохгүй дархан газар нутаг болгох төрийн бодлогыг эрхэм болгон олон улсын терроризм үүрлэх, аливаа террорист байгууллага үүсэх шалтгаан нөхцлийг гаргуулахгүй байх, террорист ажиллагааг аль болох эхлэл, үүслийн үед нь илрүүлж таслан зогсоох, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаагаа явуулах зориулалт, чиг үүрэг бүхий цагдаа, цэргийн тусгай хүчний бэлтгэл, чадавхийг байнга өндөр түвшинд байлгах, ард иргэдэд нэгдсэн ойлголт өгч сонор сэрэмжийг нь дээшлүүлэх зэрэг цогц арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал нь Монгол улсын хувьд цөөхөн улс оронд байгаа онцлог гэдгийг дээр дурьдсан. Тиймээс Монгол улсаас явуулж буй цэрэг улс төрийн бодого нь улс орны эрх ашиг, олон улсын жишигт нийцэж байгаа тохиолдолд террорист халдлагаас хол байх магадлал их, тэдний сонирхолыг татахгүй байх боломжтой.

Терроризмаас сэргийлэх үндсэн арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд гүйцэтгэх засаглалын бүх байгууллага оролцох бөгөөд Засгийн газар нь тэдгээр байгууллагын үйл ажиллагааг уялдуулан орон тооны бус “Терроризмтэй тэмцэх зөвлөл”-ийг тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулж ажиллуулна.

Зөвлөл нь терроризмтой тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үндэсний хөтөлбөр, төсөл, нэгдсэн төлөвлөгөө, тайлан, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж Ерөнхий сайдад танилцуулах, зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;терроризмтой тэмцэх чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах терроризмын нөхцөл байдал, терроризмын суурь нөхцөлийг үнэлэх дүн шинжилгээ гарган дээд удирдлагад танилцуулах, терроризмийн эсрэг үзэл сурталыг дэлгэрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хориг арга хэмжээ авахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог зохицуулах, сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах, хамтарсан сургууль, нэгдсэн дадлагыг улсын хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагын төвийг байгуулах, терроризмтой тэмцэх чиглэлээр Салбар зөвлөл, холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үүрэг, даалгавар, заавар, зөвлөмж, чиглэл өгөх, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүрэгтэй.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцуулахаар томилогдсон бүрэлдэхүүн тагнуул, цагдаа, цэрэг зэрэг бүх л татан оролцож байгаа байгууллага ажиллагааныхаа эхнээс дуусах хугацаанд нэгэн удирдлагад шилжиж, нэг бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагын дор хамтаараа үүрэг гүйцэтгэнэ.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох байгууллага, хүч хэрэгсэл нь цагдаа, тагнуул, улсын хил хамгаалах байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага,онцгой байдлын байгууллага, дотоодын цэргийн томилогдсон салбар, нэгж, терроризмтой тэмцэх Зөвлөлийн бусад бүрэлдэхүүн байгууллага, зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн захирамжаар томилогдсон зэвсэгт хүчний нэгтгэл анги, салбар байна.

*Тулгамдсан асуудал*

Дэлхий дахины даяарчлалын үйл явцад Монгол улс оролцохдоо өөрийгөө хадгалах бүхий нөхцлийг бүрдүүлэх, улс үндэстнийхээ, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах амин чухал асуудлыг төр засаг байнгын анхааралдаа байлгаж бодлого үйл ажиллагааныхаа тулгуур үндэс болгож байх ёстой.[1]

Хүн төрөлхтөнд асар их гай гамшиг тарьж буй зүйл бол яах аргагүй терроризм, террорист үйлдэл юм. Бид үүнээс хэрхэн хамгаалах ажлыг тусгайлсан чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудад дан ганц үүрүүлээд орхих нь өрөөсгөл ойлголт бөгөөд нэгдсэн удирдлага бүхий хамтын ажиллагаатай, мэдээлэл солилцох оновчтой тогтолцоог бүрдүүлж, зохицтой уян хатан, байнга тасралтгүй ажиллах системийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа билээ.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахдаа хэлбэрдэх, туйлшрахаас ангид байж, үүсэн бий болсон нөхцөл, байдал, түүний цаашдын өрнөлийг зөв тодорхойлж, оновчтой шийдвэрийг гарган, түүнийгээ тууштай хэрэгжүүлэх нь тухайн ажиллагаанд тохоон томилогдон оролцож буй хэн бүхний төр, иргэдийнхээ өмнө хүлээсэн нэн хариуцлагатай үүрэг юм.

Сөрөг тусгай ажиллагаа явуулах бүлгүүдийн үйл ажиллагаанд түүний санхүүжилт ихээхэн нөлөө үзүүлдэг ба тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хувьд алба хаагчдыг сурган бэлтгэх ажил нэн чухал бөгөөд судалгаанаас үзэхэд сөрөг тусгай ажиллагаанд үүрэг гүйцэтгэхийн тулд алба хаагчийг хамгийн доод талдаа 3 жилийн хугацаанд сэтгэл санаа, бие бялдар, тусгай чадварыг суулгах сургалтад хамруулдаг. Энэхүү сургалтад олон улсын жишгээр жилд нэг алба хаагчид 15-20 мянган ам доллар зарцуулдаг бол манай улсад дунджаар 1 мянган ам доллар ч хүрэхгүй байгаа нь нууц биш юм. Мөн

[1] *Дашзэвэг Ц., Чагнаадарж Д.. "Олон улсын терроризм ба Монгол улс". Онол практикийн бага хурлын эмхтгэл. УБ. 2004 он. 5 дахь тал*

бүхий л тусгай бэлтгэлтэй бүлгүүдийн хувьд сургалтын орчин, бэлтгэгдсэн хүний нөөц дутагдалтай байна.

**Дүгнэлт**

Терроризм, террорист үйлдэл, түүнтэй тэмцэх ажиллагаа болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага, зохион байгуулалт өнөөгийн байдал, олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Монгол улсад терроризм, түүнтэй тэмцэх ажиллагаа, сөрөг тусгай ажиллагааг явуулах мэргэжлийн байгууллагуудын чиг үүргийг терроризмтай тэмцэх тухай хуулийн тусгай хэм хэмжээ буюу тодорхойлсон хэм хэмжээгээр эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн гэж үзэж болохоор байна.
- Эрх зүйн зохицуулалтын хүрээнд мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тогтвортой, нэгдмэл удирдлагаар хангах механизм бүрдээгүй, зохион байгуулалт хангалтгүй.
- Өнөөг хүртэл терроризмтэй тэмцэх сөрөг тусгай ажиллагаа явуулах тусгай бэлтгэлтэй бүлгүүдийн үйл ажиллагаанд удирдлагын стратеги, тактикийн системийг цогцоор авч үздэггүй, үйл ажиллагаа нэгдмэл бус байна.
- Терроризмтой тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага нэгдмэл байх терроризмтой тэмцэх үндсэн зарчим хэрэгжилт хангалтгүй байна.
- Гадаадын улс орнуудын туршлагаас харахад нэгдмэл удирдлагыг хангахад олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг ба тэдний дотроос хүчийг нэг дор төвлөрүүлэн ажиллагааг удирдах нь хамгийн эрсдэл багатай зохион байгуулалт болох нь харагдаж байна.
- Сөрөг тусгай ажиллагаа явуулах мэргэжлийн нэгжүүдийг төрөөс санхүүжүүлэх төсөв, санхүүжилт хангалтгүйгээс болж шинэ зэвсэглэмж, техник технологи, сургалтын орчин бусад улс орнуудаас доогуур байгаа боловч өдийг хүртэл өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан, үйл ажиллагаагаа хэвийн явуулж ирсэн.

**Санал**

- Терроризмтой тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх хүрээнд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага нэгдмэл байх зарчмыг хангаж ажиллах;
- Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын дэргэд үйл ажиллагаа явуулж буй тусгай бэлтгэлтэй мэргэжлийн бүлгүүдийг нэгдсэн нэг ажиллагаанд ажиллуулахын тулд удирдлагын дээд түвшинд зохион

байгуулалтын арга хэмжээ авч тус тусдаа үйл ажиллагаа явуулж буй албадуудыг нэгтгэн Засгийн газрын харьяа шинээр агентлаг бий болгон нэгдсэн удирдлагын системийг төгөлдөржүүлэн үйл ажиллагааг хуваарилах;

> Террорист ажиллагааны үед ажиллах тусгай чиг үүрэг бүхий албадыг мэргэшүүлэх, тэдгээрийн харилцан ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан сургалт, сургуулийг тодорхой нөхцлөөр бэлтгэн явуулах нь террорист ажиллагаатай тэмцэх бэлтгэл хангах үндэс болно.

## Эх сурвалжийн жагсаалт


- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл.1992. №1
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон Терроризмтэй тэмцэх тухай хууль. Төрийн мэдээлэл. 2019. №41.
- Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт.
- Баатар Ч. Терроризм, аюулгүй байдал. УБ. 2006 он.
- Баярбаясгалан С. Цагдаагийн байгууллагын тусгай бэлтгэлтэй бүлгийн удирдлагыг сайжруулах асуудлууд ДХИС 2014
- Дашзэвэг Ц., Чагнаадарж Д..Олон улсын терроризм ба Монгол улс. Онол практикийн бага хурлын эмхтгэл. УБ. 2004 он.
- Дашзэвэг Ц., Чагнаадарж Д..Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд УБ. 2004 он
- Паламдорж Ш.Терроризм, түүнээс сэргийлэх. УБ. 2003 он.
- Соёлбаатар Э. Сөрөг тусгай ажиллагааны эрсдлийн удирдлагын зарим асуудал. ДХИС 2015